

ҮЙЛДВЭР ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН 2013 ОНД ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ТОВЧ ТАЙЛАН

2014.01.08

НЭГ:ХҮНД ҮЙЛДВЭР

○ “Дархан-Сэлэнгийн бүсийн төмрийн хүдрийн ордуудыг түшиглэн орчин үеийн техник, технологи бүхий төмөрлөгийн цогцолбор үйлдвэр барих” зорилтын хүрээнд:

“Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК-ийг өргөтгөн, Дархан-Сэлэнгийн бүсийн Төмөртолгой, Төмөртэй, Баянгол, Хуст-Уулын төмрийн ордуудыг түшиглэн 2010-2015 онуудад “Уул уурхай-хар төмөрлөгийн цогцолбор” байгуулах төслийг хэрэгжүүлж байна. Төслийн ажын гүйцэтгэл 50 хувьтай.

Төслийн 1 дүгээр үе шатны ажлын хүрээнд:

- Төмөртолгойн төмрийн хүдрийг хуурай соронзон аргаар баяжуулах боловсруулах үйлдвэр, дэд бүтцийн хамт байгуулан, бүрэн хүчин чадлаар ашиглалтанд оруулсан. Хоногийн нийт хүчин чадал 5000,0 тн, баяжмалын гарц 65-70%, металл авалт 82%, баяжмал дахь төмрийн агуулга 56-62% байна



- Төмөртэйн орд дээр жилд 2 сая тонн хүдэр хуурай соронзон аргаар баяжуулах үйлдвэр баригдаж байна. Тоног төхөөрөмж нийлүүлэгдсэн, үйлдвэрийн суурийг цутгах ажил эхэлсэн, угсралтын ажлын явц 80% байна.

- Дарханы төмөрлөгийн үйлдвэрийн дэргэд жилд 1 сая тонн төмрийн хүдрийг нойтон соронзон аргаар баяжуулах үйлдвэр барьж байна. Тоног төхөөрөмжийн сонголт хийгдэж суурилуулалт **болон барилга** угсралтын ажил 90%-н гүйцэтгэлтэй.



- Дарханы төмөрлөгийн үйлдвэрийн технологийн шугамыг өргөтгөх хүрээнд дараах тоног төхөрөмж худалдан авч, суурилуулах бэлтгэл ажил явагдаж байна. Үүнд:
 - цувих цехийн хүчин чадлыг нэмэгдүүлэх ган бөмбөлгийн бэлдэц цувих шугам
 - цэвэршүүлсэн нүүрсний хийн станцийн тоног төхөөрөмжМөн хайлах цехт байрлуулах шанаган зуухны техник технологийн болон шууд ангижруулсан төмрийн үйлдвэр, үйлдвэрийн өргөтгөлийн суурь судалгаанууд хийгдсэн. Технологийн болон хагас үйлдвэрлэлийн туршилтаар тодотгох, баталгаажуулах ажлууд хийгдэж байна.
- “Уул уурхайн бүтээгдэхүүнийг боловсруулах зорилгоор аж үйлдвэрийн анхны паркийг Дорноговь аймгийн Сайншанд хотод байгуулах” зорилтын хүрээнд:

- ТӨХ-ны 2013 оны 3 дугаар сарын 21-ний өдрийн “Компанийн хэлбэрийг өөрчлөн байгуулж, Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг томилох тухай” 107 дугаар тогтоолоор “САҮЦ” ХХК-ийн зохион байгуулалтын хэлбэрийг төрийн өмчийн 34 хувийн оролцоотой хаалттай хувьцаатай компани болгон өөрчлөн байгуулсан.

- Дорноговь аймгийн Засаг даргын 2013 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн А/325 тоот захирамжаар Сайншандын аж үйлдвэрийн цогцолборын зориулалтаар улсын тусгай хэрэгцээнд авсан 3512.5 га газрыг “Сайншанд аж үйлдвэрийн цогцолбор” Төрийн өмчийн оролцоотой хаалттай хувьцаат компанид 15 жилийн хугацаатай эзэмшүүлэх шийдвэр гарчээ.

- ТУЗ-ийн 2013 оны 22 тоот тогтоолоор Дорноговь аймаг дах суурин Төлөөлөгчийн газар байгуулах шийдвэр гарган, дүрмийг баталсан. Суурин Төлөөлөгчийн газрыг 2013.06.21-нд нээсэн.

- Засгийн газрын 2013 оны 76 дугаар тогтоолоор зөвлөх үйлчилгээнд 2013 онд шаардагдах 14,170,8 (арван дөрвөн тэрбум нэг зуун далан сая найман зуун мянган) сая төгрөгийг зохих журмын дагуу **Хөгжлийн банкнаас** санхүүжүүлэхээр шийдвэрлэсэн.

2013 оны улсын төвлөрсөн төсөв, Хөгжлийн банкны зээлийн хөрөнгөөр санхүүжүүлж буй 8 сонгон шалгаруулалтаар дараах ажлыг гүйцэтгэв. Үүнд:

- Хуулийн зөвлөх үйлчилгээний ажлыг “Тейлор Вессинг” ба “Легал Полиси” ХХК нартай түншлэлийн гэрээ байгуулан гүйцэтгүүлж байна, ажлын эхний тайланг хүлээн авав.

- Төслийн ерөнхий зөвлөхийн ажлыг гүйцэтгэгчээр шалгарсан “Флуор” компани гүйцэтгэж байна, ажлын эхний тайланг хүлээн авав.

- Газар доорхи усны нарийвчилсан хайгуулын ажлыг шалгарсан “Тунгалаг-Ус” ХХК-ийн түншлэлийн гэрээгээр гүйцэтгэж байна. Ажлын гүйцэтгэл 30 орчим хувьтай.

- Бүс нутаг хооронд ус дамжуулах байгууламжийн ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах ажлыг “Монхидроконстракшн” ХХК гэрээгээр гүйцэтгэж байна. Ажлын явц 30 орчим хувь.

- САҮЦ-ийн эрчим хүчний дэд станц барьж байгуулах ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээний ажлыг “Монэнержи консалт” ХХК гүйцэтгэж байна.

- САҮЦ-ийн суурьшлийн бүсийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний зөвлөх үйлчилгээг “Гоби травел” ХХК гүйцэтгэж байна.

- Цогцолборын байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ хийх ажлыг гүйцэтгэгчээр шалгарсан “Натур фрейдли” ХХК-тай гэрээ байгуулан, гүйцэтгүүлж ажил эхлээд байна.

- САҮЦ-ын Инженер-геологийн хайгуулын ажил, судалгаа, байр зүйн зураглал хийх зөвлөх үйлчилгээний нээлттэй тендер шалгаруулалтыг дахин зарлах болсон.

- “Нүүрснээс хий, шингэн түлш гаргах ажлыг эрчимжүүлж, шатдаг занар, нүүрсний химийн үйлдвэрийг хөгжүүлэх судалгааг хийх” зорилтын хүрээнд:

- Засгийн газрын 2013 оны 246 дугаар тогтоолын дагуу Нүүрс шингэрүүлэх үйлдвэрийг 51 хувийн төрийн өмчит компани байгуулах бэлтгэл ажлыг хангах Төслийн нэгжийг ҮХАА-н сайдын 2013 оны А/101 дүгээр тушаалаар байгуулан, компанийн дүрэм, бүтцийн төслийг гарган, компани байгуулах тухай Засгийн газрын тогтоолын төсөл бэлдэх, “Үндсэн технологи нийлүүлэгчийг сонгох тухай”, “Монголын аж үйлдвэрийн корпораци” ХХК-ийн техник-эдийн засгийн үндэслэлд оруулах шинэчлэх ажлыг хийж гүйцэтгэв.

- 2013 оны 11 дүгээр сарын 01-нд Сайдын тушаалаар ХБНГУ-ын “ТиссенКрупп Үдэ” компанийг үндсэн технологи нийлүүлэгчээр сонгон, хамтран ажиллах гэрээ байгуулсан.

- Төрийн өмчийн хорооны 2013 оны 631 дугаар тогтоолоор “Си Ти Эл Монголиа” Төрийн өмчит хувьцаат компани байгуулахаар шийдвэрлэгдсэн. Төрийн өмчийн хороо нь компанийн бүтцийг баталж, гүйцэтгэх захирлыг томилсон.

ХОЁР: МАЛ АЖ АХУЙН ҮЙЛДВЭРЛЭЛ

- Хадлан, тэжээл бэлтгэх техник, тоног төхөөрөмжийн хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор 2013 оны төсвийн хөрөнгөөр өвс хуйлж боох 45 техник, цагт 2 тн тэжээл үйлдвэрлэх хүчин чадалтай 17 иж бүрдэл үйлдвэр, битүү орчинд ногоон тэжээл ургуулах 15 үйлдвэр худалдан авах ажиллагааг зохион байгуулж, шаардлагад нийцсэн техникийг хүлээн авч иргэд, аж ахуйн нэгжүүдэд хөнгөлөлттэй нөхцөлтэйгээр олгох арга хэмжээг хэрэгжүүлсэн.

- Техник, тоног төхөөрөмжийг олгосноор хадлан бэлтгэлд 4922 дугуйт трактор, 434 хаман боогч, 3170 морин хадуур, тармуур ашиглаж **малчдын түвшинд** 1.1 сая тн өвс, 21.7 мянган тн сүрэл,

42.2 мянган тн ногоон тэжээл, 40.7 мянган тн үйлдвэрийн тэжээл, 45.9 мянган тн гар тэжээл бэлтгэж төлөвлөгөөт зорилтыг 82.5 хувиар хангав. 2013 онд хураан авсан үр тарианаас 25.4 мянган тн тэжээлийн будаа руу шилжиж, гурилын үйлдвэрээс 65.0 мянган тн хивэг үйлдвэрлэх тооцоо гарч байгаа нь нийт хүчит тэжээлийн хэмжээг 90.4 мянган тонноор нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлсэн. Засгийн газрын 210 дугаар тогтоолоор өгсөн аймаг, сумын аюулгүйн нөөц бүрдүүлэх даалгавар **аймгийн түвшинд** 9.1 мянган тн өвс бэлтгэж 71.1 хувь, **сумын түвшинд** 16.3 мянган тн өвс бэлтгэж **76.7** хувь тус тус биелэлттэй байна.

- Улсын хэмжээнд 2013-2014 онд нийт 145.0 мянган малчин өрхөд 44.3 сая толгой малыг өвөлжүүлэх бэлтгэл ажлын зохион байгуулалтыг хангаад байна. Хүнсний хэрэгцээнд 8.0 сая малыг маханд зориулан хэрэгцээлээд байна.
- Улсын хэрэгцээний отрын бүс болох Дорнод, Хэрлэнбаян-Улаанд 11 хашаа, Төвийн бүсийн нутагт 500 тоннын багтаамжтай өвсний 2 саравч, 200 тн тэжээлийн багтаамжтай битүү агуулах тус тус барьж ашиглалтад оруулаад байна. Орон нутгийн 20 гаруй хувь нь өөрийн сумын нутагт мал өвөлжүүлэх боломж муу байна. Тиймээс бэлчээрийн даац хэтэрсэн отор хийж өвөлжих өрх, малын тоог тохиролцон орон нутгууд гэрээ байгуулан өөр аймгийн нутагт 3253 өрхийн 965.0 мянга, өөрийн аймгийн бусад сумын нутагт 6799 өрхийн 2.1 сая, аймаг, дундын тусгай хэрэгцээний отрын бүс нутагт 743 өрхийн 473.9 мянга, улсын хилийн зурвас газарт 2780 өрхийн 864.0 мянга, улсын тусгай хамгаалалттай бүс нутагт 3145 өрхийн 1113.3 мянган мал нийт 17.1 мянган өрхийн 5.7 сая мал отроор өвөлжиж, хаваржихаар гэрээ байгуулсан.
- 2013 онд 361.0 мянган хээлтүүлэгчид үзлэг, ангилалт аттестатчилал хийж үржилд тэнцэхгүй хээлтүүлэгчийг заазлах, шинээр нөхөн тавих баталгаажуулах, чиглэлтэй өсгөн бойжуулах ажлыг зохион байгуулав. Үржилд ашиглаж байгаа нийт хээлтүүлэгчийн 94.0 хувь үүнээс азраганы 97.1, буурны 95.8, бухны 95.7, хуцны 93.4, ухны 92.9 нь стандартын шаардлага хангасан дүн гарсан байна.
- Улсын хэмжээнд нийт 45.2 мянган хээлтүүлэгч, үүнээс 21.0 мянган хурган хуц, 16.7 мянган ухнан ишгийг шинээр нөхөн тавьж төрийн өмчит цөм сүргийн үржлийн 12 аж ахуйнуудаас 926 үржлийн мал бойжуулж иргэд, аж ахуйн нэгжийн хэрэгцээнд нийлүүлэх ажлыг зохион байгуулав.
- Батлагдсан хуваариар уст цэг тогтоох хайгуулийг 417 уст цэгийг 500.0 сая төгрөгт Баянхонгор, Баян-Өлгий, Булган, Өмнөговь, Сүхбаатар, Увс, Хэнтий, Говьсүмбэр аймгуудад, 18 аймагт 407 инженерийн хийцтэй худгийг 6.5 тэрбум төгрөгт гаргах ажлыг тус тус зохион байгуулсан. 2013 оны жилийн эцсийн мэдээгээр 6.2 тэрбум төгрөгөөр 408, гадаадын төсөл хөтөлбөрийн 1.6 тэрбум төгрөгөөр 101, орон нутгийн төсвийн 2.1 тэрбум төгрөгөөр 254 инженерийн хийцтэй нийт 763 худгийг бэлчээрт шинээр барьж байгуулснаас гадна малчдын санаачлагаар гар худаг шинээр 388, нийт 1108 худаг гаргасан нь 1.4 сая га бэлчээр, 5600 малчин өрх, 3.1 сая малын усан хангамжийг нэмэгдүүлэх нөхцөл боломжийг бүрдүүлэв.
- Бэлчээрийн ургамалд хөнөөл учруулж буй үлийн цагаан оготной тэмцэх арга хэмжээг энгийн механик, биологийн аргаар 500.0 мянган га-аас доошгүй талбайд 785.0 сая төгрөгт хийхээр Баян-Өлгий, ГовьАлтай, Увс, Ховд аймгуудад 105.0 мянган га талбайд хийхэд шаардагдах зардлыг 404.0 сая, шаардагдах 21.0 мянган литр “Карате-5%” бэлдмэлийг 158.8 сая төгрөгний бэлдмэлээр 13 аймгийн 88 сум, 2 отрын бэлчээрийн 645.0 мянган га талбайд, царцаатай тэмцэх ажлыг 4 аймгийн 21 сумын 105.0 мянган га бэлчээрийн талбайд тус тус гүйцэтгэж нийт 17 аймгийн 725.0 гаруй мянган га бэлчээрийн талбайг хортон шавьж, мэрэгч амьтнаас хамгаалж, бэлчээрийн ургамлын нөхөн сэргээх нөхцлийг бүрдүүлсэн.
- Монгол улсын Малчин мэргэжлийн үнэмлэх, тэмдэгийг бүх аймгуудад 2013 оны 3 дугаар сарын 28-ны өдөр хүргүүлэн нийт 326.0 мянган малчинд хүргэх ажлыг сумдын Мал эмнэлэг үржлийн тасгаар гүйцэтгүүлэх ажлыг зохион байгуулав. Үнэмлэх, Тэмдгийн олголт жилийн эцсийн урьдчилсан дүнгээр 95 хувь буюу 310 мянган малчинд олгоод байна.
- Үндэсний үйлдвэрүүдэд тушаасан хонь, тэмээний ноосонд урамшуулал олгох ажлыг 2011 онд 4.9 мянган тн ноосонд 9.8 тэрбум төгрөг, 2012 онд 14.7 мянган тн ноосонд 29.4 тэрбум төгрөг тус тус олгож үндэсний үйлдвэрүүд түүхий эдийн хомсдолоос гарч, бүтээгдэхүүн үйлдвэрлэл эрс нэмэгдэн борлуулалтын орлого 2011 онд 49.2 тэрбум, 2012 онд 77.4 тэрбум төгрөгт хүрч, 2011 онд 7.5 тэрбум, 2012 онд 9.6 тэрбум төгрөгийн татвар төлсөн нь жилд 2-3 тэрбум төгрөгөөр өссөн дүнтэй байна. 2013 оны жилийн эцсийн урьдчилсан дүнгээр 18.4 мянган тонн ноосыг үндэсний үйлдвэрүүдэд тушааж, 36.8 тэрбум төгрөгний урамшуулал олгохоос 18,3 тэрбум төгрөгийг олгоод байна.

- Малын тоо жил дараалан төрөл тус бүрдээ өсч 2013 оны эцсийн байдлаар 45.1 сая мал тоологдсоны дотор тэмээ 0.7, адуу 5.8, үхэр 6.4, хонь 44.5, ямаа 42.6 хувийг тус тус эзэлж байна. Нэгжээс авах ашиг шимийн хэмжээ харьцангуй тогтвортой, дунджаар эрлийз үнээнээс 2285 литр сүү, нутгийн хониноос 1.2 кг, нарийн нарийвтар ноост хониноос 4.1 кг ноос, нутгийн ямаанаас 295 грамм ноолуур авч байна.
- Засгийн газрын 2012 оны 188 дугаар тогтоолоор Биржийн зохицуулах зөвлөлийн гишүүдийг томилж, зөвлөлийн дүрэм, үйл ажиллагааны журмыг баталсан. “Хөдөө аж ахуйн бирж” Төрийн өмчит хуулийн этгээд байгуулагдаж, үйл ажиллагаагаа 2013 оны 4 дүгээр сарын 5-ны өдөр эхлүүлсэн.
- Эрчимжсэн мал аж ахуйг дэмжих хөтөлбөрийн 2013 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулан сүүний үхэр, ямаа, гахай, тахиа, аж ахуй эрхлэгчдэд 2.6 тэрбум зээлийн дэмжлэгийг 106 аж ахуйн нэгжид үзүүлэв.
- Засгийн газар, Монгол банкны хооронд байгуулсан “Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах” дунд хугацааны хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлэх харилцан ойлголцлын санамж бичгийн хүрээнд эхний ээлжинд 3 иргэн, 40 аж ахуйн нэгжид 46.5 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгохоор шийдвэрлэж эхний санхүүжилтийг аж ахуйн нэгжүүд авч үйл ажиллагаагаа эхлүүлээд байна.
- “Сүүний чиглэлийн цэвэр үүлдрийн ямаа импортлож, үржлийн аж ахуй байгуулах” төсөл сонгон шалгаруулалт явуулж 450 сая төгрөгний хөнгөлөлттэй зээл олгосноор 2013 оны 6 дугаар сарын 19-ний өдөр Франц улсаас сүүний чиглэлийн Альпин үүлдрийн 202 толгой ямаа, аж ахуйн хөрөнгөөр Франц улсаас 210 толгой мах-сүүний Монбелярд үүлдрийн үхрийг оруулж гадаадын өндөр ашиг шимт малыг өөрийн оронд нутагшуулах, малын удмын санг сайжруулах нөхцөл бүрдээд байна.
- Биокомбинат ТӨААТҮГ-тай Мал эмнэлгийн зориулалт бүхий биобэлдмэл нийлүүлэх гэрээг байгуулж, 25 нэр төрлийн 143.9 мянган литр шингэн, 27.6 мянган тун хатаасан биобэлдмэлийг 5.1 тэрбум төгрөгний үнэ бүхий вакцин 7 нэрийн халдварт өвчний оношлоход шаардагдах 90.4 литр шингэн, 35.5 мянган тун хатаасан 27.9 сая төгрөгний оношлуурыг нийлүүлэх арга хэмжээг зохион байгуулсан.
- Малын гоц халдварт өвчнөөр 2013 онд хонины цэцэг өвчин Дорноговь аймгийн Хатанбулаг суманд, шүлхий өвчин Баян-Өлгий, Дорнод аймагт тус тус оношлогдож, уг өвчний голомтыг богино хугацаанд устгаж 2014 оны 1 дүгээр сарын байдлаар олон улсын хорио цээрт өвчнөөр тайван байна.
- Мал, амьтны гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх 2013 оны нэгдүгээр ээлжийн вакцинжуулалтын арга хэмжээнд Хэнтий, Дорнод, Сүхбаатар, Дорноговь, Говьсүмбэр аймгийн 62 сумын шүлхийд мэдрэмтгий давхардсан тоогоор 20.6 сая малыг вакцинжуулалтад хамруулсан.
- Баруун бүсэд гоц халдварт шүлхий өвчин гарсантай холбогдуулан Баян-Өлгий, Ховд, Увс аймгийн 22 сумын давхардсан тоогоор 6.5 сая малыг дархлаажуулж, 1.6 тэрбум төгрөгний үйлчилгээний хөлсийг Засгийн газрын нөөц хөрөнгөөс гарган олгуулах ажлыг зохион байгуулсан. Улсын хэмжээнд гоц халдварт шүлхий өвчнөөс сэргийлж дархлаажуулах арга хэмжээг 8 аймгийн 84 сумын давхардсан тоогоор 27.1 сая малыг дархлаажуулав.
- Мал, амьтны халдварт, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулахад сумдын 879 мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүд хэрэгжүүлж, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 22 аймаг, нийслэлийн давхардсан тоогоор 44.3 сая толгой, гоц халдварт шүлхий өвчнөөс сэргийлж дархлаажуулах арга хэмжээнд 8 аймгийн 84 сумын давхардсан тоогоор 27.1 сая малыг тус тус дархлаажуулах арга хэмжээг технологит хугацаанд нь хэрэгжүүлсэн.
- Ариутгал халдваргүйжүүлэлтийн арга хэмжээнд 20507.8 мянган метр м² талбайд халдваргүйжүүлэлт хийж өвчин гарах эрсдлийг бууруулав.

ГУРАВ: ГАЗАР ТАРИАЛАНГИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ

2013 оны ургац хураалтын дүнгээр нийтдээ 291.9 мянган га-гаас 388.7 мянган тонн үр тариа, 190.1 мянган тонн төмс, 102.2 мянган тонн хүнсний ногоо, 43,7 мянган тонн тэжээлийн ургамал буюу нэгжээс 14.0 цн улаанбуудай, 129.0 цн төмс, 125.2 цн хүнсний ногоо, 27 цн тэжээлийн ургамал тус тус хураан аваад байна.

Газар тариалангийн үйлдвэрлэл

/ тонноор/

	2008 он	2009 он	2010 он	2011 он	2012 он	2013 он
Үр тариа	205846	393244	366748	448128	475901	388752
Төмс	156018	156950	169298	199215	242750	190645
Хүнсний ногоо	81475	81760	90449	105231	98480	102250
Малын тэжээл	15731	14475	41600	34338	45611	43689

Монгол банкны Ерөнхийлөгч, Үйлдвэр, хөдөө аж ахуйн Сайдын хамтарсан тушаалаар “Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах” дэд хөтөлбөрийн хүрээнд:

- 23 гурилын үйлдвэрт 48.7 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгосноор 1 дүгээр гурилын бөөнийг үнэ 550 төгрөг, жижиглэнгийн үнэ савалгаанаасаа хамаарч 650-700 төгрөгөөр борлуулагдаж жилийн турш үнэ тогтвортой байсан нь инфляцид эерэгээр нөлөөлсөн арга хэмжээ боллоо.
- Төмс, хүнсний ногооны зоорь, агуулах, худалдааны төв байгуулах, өргөжүүлэх зорилгоор 33 төсөлтэй 88,4 төгрөгийн хөнгөлөлттэй зээлийн гэрээ байгуулж байна. Үүнд: Төмс, хүнсний ногооны зоорь, агуулах худалдааны төв байгуулах 15 төсөл, мах махан бүтээгдэхүүн хадгалах зоорь, худалдааны төвийн 18 төсөл байна. Уг төсөл бүрэн хэрэгжсэнээр төмс, хүнсний ногооны зоорийн багтаамж 45,0 мянган тн, мах махан бүтээгдэхүүний зоорийн багтаамж 15,0 мянган тонноор нэмэгдэх боломжтой юм.
- Улсын хэмжээнд 2013 оны эцсийн байдлаар 182,0 мянган тонн багтаамжтай 3200 гаруй зоорь ашиглаж байна. Нийт 294,0 мянган тонн төмс, хүнсний ногоо хураан авснаас төмс 192,0 мянган тонн, хүнсний ногоо 102,0 мянган тонныг эзэлж байна. Зоорийн нийт багтаамжийг хураан авсан ургацтай харьцуулахад хадгалах хүчин чадлын хангамж 61,9 хувьтай байна.

- Үтрэмийн аж ахуйд техникийн шинэчлэл хийх, технологийн дэвшилд нийцсэн агуулах барьж ашиглалтад оруулах зорилгоор:

- 300, 500 тоннын багтаамжтай босоо төмөр элеватор 50 ширхэгийг нийлүүлж аж ахуйн нэгж, иргэдэд 50 хувийн хөнгөлөлттэй үнээр олгосноор буудай хадгалах агуулахын хүч чадлыг 20.0 мянган тонноор нэмэгдүүлсэн
- Төв аймгийн Угтаалцайдам сумын төвд дутуу баригдсан 36.0 мянган тоннын элеваторыг Япон Улсын Засгийн газрын төслийн бус буцалтгүй тусламжийн 3.4 тэрбум төгрөгийн хөрөнгөөр засварлаж ашиглалтад оруулав.

- Газар тариалангийн салбарын бага механикжуулалтын түвшинг сайжруулах, төмс, хүнсний ногооны үйлдвэрлэлийг эрчимжүүлэх зорилгоор бага оврын тракторт нийцсэн төмс, хүнсний ногооны иж бүрдэл 110 ширхэг, үрслэг суулгагч машин 33 ширхэг, төмсний үрлэгч, ухагч 76 ширхэгийг тус тус нийлүүлж, хөнгөлөлттэй нөхцлөөр олгож эхэллээ. Дээрх тоног төхөөрөмжийг үйлдвэрлэлд ашигласнаар 180 ногоочдын гар хөдөлмөр механикжсан. 2013 онд нийлүүлэгдсэн 100 иж бүрдэл техникийг ногоочдын бүлэгт олгон нийт 700 ногоочдын гар хөдөлмөр механикжив.



- Ногоочдынхоо тарьж ургуулсан төмс, хүнсний ногооны борлуулалтыг дэмжих, хэрэглэгчдийн хэрэгцээнд чанар сайтай бүтээгдэхүүний шууд нийлүүлэх ажлыг нийслэл хотын 6 дүүргийн 28 хэсэгт 300 гаруй лангуу байгуулан ажиллуулснаар эрт ургацын 5400 тонн ногоог үйлдвэрлэгчээс шууд хэрэглэгчдэд хүргэх арга хэмжээг зохион байгууллаа.



- Чингис бондын хөрөнгөөр өвлийн шилэн хүлэмж барих төслийг хэрэгжүүлж нийслэл хотод 20 га, орон нутагт 12 га, нийтдээ 32 га талбайд хүлэмжийн төрөлжсөн аж ахуй байгуулахаар Голланд Улсын Эдийн Засгийн харилцааны яамтай хамтран ажиллаж төслийг эхлүүлээд байна.



-“Жимс жимсгэний суулгац үржүүлгийн плантаци байгуулах”-д зориулан 750.0 сая төгрөгийн зээлийн дэмжлэг, “Жимс жимсгэний 770.0 мянган ширхэг суулгац, гүзээлзгэний 60.0 мянган ширхэг суулгацыг нийлүүлж 200 гаруй аж ахуйн нэгж, иргэдэд зээлээр олгож тариалав.



- Усалгаатай тариалангийн хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор Улсын төсвийн хөрөнгөөр төрийн болон орон нутгийн өмчийн 1048 га талбайг услах хүчин чадал бүхий 10 усалтын системийг шинээр барих, сэргээн засварлах барилгын ажил хийгдэв.

ДӨРӨВ:ХҮНСНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ

Мах

- “Хүнсний гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах” дэд хөтөлбөрийн хүрээнд нийт 11446.1 тн махны нөөц бэлтгэн, 87.0 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг шалгарсан 3 аж ахуйн нэгжид олгосны үр дүнд 2013 оны хаврын улирлын хэрэгцээнд зориулан 11,4 мянган тонн мах бэлтгэн нөөцлөж, худалдан борлуулах ажлыг 2013 оны 1-7 дугаар саруудын хооронд зохион байгуулав.

- Мах, махан бүтээгдэхүүний үнийн өсөлт өмнөх оноос буурч жилийн инфляцийн түвшин 2013 оны 7 дугаар сарын байдлаар 6.2 хувьтай байгаа нь өмнөх 5 жилийн дундаж өсөлтөөс 3.7 дахин бага байна.

- 2014 онд Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотын хүн амын хэрэгцээнд махны нөөц бүрдүүлэх, хадгалах, ангилан савлах, худалдаалах үйл ажиллагааг зохион байгуулах үүрэг бүхий “Нөөцийн махны менежер”-ийг 2013 оны 9-10 сард сонгон шалгаруулж, 4 компанитай гэрээ байгуулан ажиллаж эхлээд байна. Хөтөлбөрийн хүрээнд 2014 онд нийт 14,0 мян.тн махны нөөц бүрдүүлж, худалдан борлуулж байна.

2014 оны нөөцийн махны борлуулалтыг 12 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн зохион байгуулж, Улаанбаатар хотод 40 гаруй, Эрдэнэт хотод 10 дэлгүүрт нөөцийн махны жижиглэн худалдаа гаргасан.

Гурил

- “Гурилын үнийг тогтворжуулах” хөтөлбөрийн хүрээнд 23 гурилын үйлдвэрт жилийн 3,8 хувийн хүүтэй 48,7 тэрбум төгрөгийн зээл олгосон ба үүний үр дүнд 1 кг нэгдүгээр зэргийн гурилын бөөний үнийг 550, жижиглэнгийн үнийг 650 төгрөгт тус тус барих гэрээний үүргээ биелүүлж ажилласан.

2013 оны 12 дугаар сарын байдлаар тухайн онд төлөгдөх ёстой нийт зээлийн эргэн төлөлт 33,2 тэрбум төгрөг буюу 138,3%-тай байна.

Сүү

- Монгол Улсын Засгийн газрын үнэт цаас арилжаалж бүрдүүлсэн хөрөнгөөс санхүүжих “Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл” төслийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “саалийн эрчимжсэн фермийн аж ахуй-боловсруулах үйлдвэр-хэрэглэгч”, “мал бүхий иргэд-саалтуурын зогсоол- сүү боловсруулах цех-дахин савлагааны үйлдвэр-хэрэглэгч” гэсэн зарчмаар сүүг үнээний дэлэнгээс хэрэглэгч хүртэлх тээвэрлэлт, ханган нийлүүлэлтийн өртгийн сүлжээний загварыг боловсруулсан.

- Дотооддоо үйлдвэрлэх бололцоотой шингэн сүү, тараг, цөцгийн тос, зайрмаг, бяслаг зэрэг бүтээгдэхүүний импортын гаалийн албан татварын хувь хэмжээг Дэлхийн худалдааны байгууллагын өмнө хүлээсэн үүргийн дээд хувь хэмжээнд нэмэгдүүлэх саналыг боловсруулж Сангийн яаманд хүргүүлсэн.

- “Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл” төслөөс зээл авахаар шалгарсан сүүний бага оврын цехийн төсөлд оролцож буй 26 аж ахуй нэгжийн төсөл, үхрийн фермийн төсөлд оролцож буй 14 аж ахуй нэгжийн жагсаалтыг Зээлийн батлан даалтын санд хүргүүлэв.

- “CHF” ОУ-ын байгууллагатай хамтран Сэлэнгэ аймгийн Мандал суманд өдөрт 2 тн сүү боловсруулах үйлдвэрийн төсөл боловсруулж, CHF ОУ-ын байгууллага болон Мандал сумын ЗДТГ-тай хамтран хөрөнгийн асуудлыг шийдвэрлэхээр ажиллаж байна.

- Өвөрхангай аймгийн Уянга, Хужирт, Зүүнбаян-Улаан, Бат-Өлзий суманд хоногт 1000 тонн сүү боловсруулах үйлдвэрийг байгуулж, ажлыг нь жигдрүүлсэн.

- Засгийн газрын 2013 оны 4 дүгээр сарын 13 –ны өдрийн 141 тоот тогтоолоор “Чингис бонд”-ын зээлд 500 литр сүү боловсруулах 86 цех байгуулах, 3,87 сая ам.долларын зээлийг зөвшөөрүүлсэн. “Сүү сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл” төслийн хэрэгжүүлэх нэгж дээр төсөл сонгон шалгаруулалт хийж, шаардлага хангасан 28 төслийг ТУХ-ын хурлаар оруулан дэмжүүлж, Голомт банкинд хүргүүлсэн.

Өндөг

- Өндгийг хадгалах, ангилан савлах нэгдсэн сүлжээ бүхий борлуулалтын бөөний цэгийг байгуулав.

Бусад арга хэмжээ

- 2013 оны 8 дугаар сард зохион байгуулсан “Намрын ногоон өдрүүд” нэгдсэн арга хэмжээний хүрээнд зохион байгуулагдсан “Эрүүл хүнс-2013” үзэсгэлэн худалдаанд 127 дотоодын хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгч 853 нэр төрлийн бүтээгдэхүүнээр оролцож, 96,5 сая төгрөгийн борлуулалт хийсэн байна

Түүнчлэн “Алтан намар” үзэсгэлэнд оролцогчид 350.8 тонн төмс, 504.5 тонн хүнсний ногоо, 8000 шил нөөшилсөн ногоо, 2.0 тн зөгийн бал, 1.5 тонн чацаргана, 0.1 тонн үхрийн нүд, 3 тонн байгалийн жимс болон 6650 ширхэг жимс жимсгэнийн суулгац зэрэг бүтээгдэхүүнээр нийт 541.4 сая төгрөгийн борлуулалт хийсэн байна

- 2013 онд экспортлох, импортлох малын мах, буудайн гурил, сүү, ундны савласан цэвэр усны нэр төрөл, тоо хэмжээний талаарх саналыг боловсруулан Хүнсний аюулгүй байдлын Үндэсний зөвлөлд танилцуулсан.

Үндэсний зөвлөлөөс ирүүлсэн зөвлөмжийг үндэслэн

Эспортлохоор – хонины мах 2,0 мян.тн, адууны мах 7,5 мян.тн, яманы мах 750,0 тн, ундны савласан цэвэр ус 100,0 тн-ыг;

Импортлохоор – үхрийн мах 2,0 мян.тн, гурил 50,0 мян.тн, хуурай сүү 4,2 мян.тн, үйлдвэрийн аргаар боловсруулсан шингэн сүү 350,0 тн, ундны цэвэр ус 3,0 мян.тн-ыг тус тус тогтоож, яамны цахим хуудас болон эрх зүйн мэдээллийн нэгдсэн системд байршуулан олон нийтэд мэдээлж, сонгон шалгаруулав.

- Стратегийн хүнсийг экспортлох, импортлох зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтыг зохих журмын дагуу явуулж, хонь, адууны мах 6,4 мян.тн экспортлох зөвшөөрлийг 11 ХХК, үхрийн мах 143,0 тн импортлох зөвшөөрлийг 3 ХХК-д, үйлдвэрийн аргаар боловсруулсан шингэн сүү 279,0 тн импортлох зөвшөөрлийг 1 ХХК-д, хуурай сүү 998,2 тн импортлох зөвшөөрлийг 4 ХХК-д, 21,0 мян.тн улаан буудайн гурил импортлох зөвшөөрлийг 14 ХХК-д, ундны савласан цэвэр ус 447,0 тн импортлох зөвшөөрлийг 3 ХХК-д тус тус олгов. Энэ талаарх мэдээллийг нийтэд яамны цахим хуудсаар зарлаж, МХЕГ, ГЕГ-т албан тоотоор хүргүүлэв.

- Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн дэх малын эм, биобэлдмэлийн болон пестицидийн үлдэгдлийн зөвшөөрөгдөх дээд хэмжээг тогтоож Сайдын тушаалаар баталгаажуулав. Үндэсний стандартын үлдэгдлийн стандартын үзүүлэлттэй харьцуулан судалсан.

- Хүнсний тухай болон Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулиуд батлагдсантай холбогдуулан 13 дүрэм журмыг боловсруулж дуусган Засгийн газрын тогтоол болон салбарын Сайдын тушаалаар баталгаажуулсан.

ТАВ: ХӨНГӨН ҮЙЛДВЭР

Хөдөө аж ахуйн биржийн талаар

-4 дүгээр сарын 5–ны өдөр ноолуурын туршилтын арилжааг амжилттай эхлүүлсэн. 2013 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар 6382.1 тн ноолуур - 385.2 тэрбум төгрөг, 1005 тн хонины ноос – 1.5 тэрбум, 1 048 тн тэмээний ноос - 5 тэрбум, 14 912 тн тосны ургамал /рапс/-11.9 тэрбум, нийт 403.6 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн байна.

- Биржийн бараа.Ямааны ноолуур. Техникийн шаардлага MNS 6375:2013, Биржийн бараа.Хонины ноос.Техникийн шаардлага MNS 6376:2013 стандартыг батлуулан мөрдөж эхэлсэн.ҮХАА-н сайдын 2013 оны А/35 дугаар тушаалаар Бараа түүхий эдийн ангиллын кодыг батлуулсан.

- Санхүүгийн зохицуулах хорооноос 32 брокерийн компани тусгай зөвшөөрөл авсан. Одоогоор 21 аймаг, зүүн аймгийн 49 сум, Улаанбаатар хотын 11 компани биржийн сүлжээнд холбогдон үйл ажиллагаагаа явуулж байна

Ноос, ноолуур, арьс ширний үйлдвэрлэл

-2013 онд үндэсний үйлдвэрүүд хүлээн авсан ноосны хэмжээ 2011 оныхоос 3.7 дахин өсч, бэлтгэсэн ноосны 95 хувийг дотоодын үйлдвэрт нийлүүлсэн байна.

-Дархан, Эрдэнэт хот, Багануур дүүргийн паркийн бүсд үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгжийн талаар болон цаашид хүрэх үр дүнгийн тухай танилцуулгыг Сайдын зөвлөлийн 2013 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж чиглэл авсан. Мөн эдгээр паркийн захиргаатай байгуулах гэрээний төслийг боловсруулсан.

- Ноос, ноолуурын ҮТП байгуулах судалгаа, ТЭЗҮ боловсруулах ажлын даалгаврыг боловсруулж, ХААГ-т хүргүүлсний дагуу зөвлөх үйлчилгээний тендер шалгаруулан гэрээ хийж, тайланг хүлээн авсан.

-Арьс ширний лабораторийг чадавхижуулах судалгаа, ТЭЗҮ боловсруулах зөвлөх үйлчилгээний Тендерийн ажлын даалгаврыг боловсруулж, Худалдан авах ажиллагааны газарт хүргүүлсэн. Шалгарсан оролцогчтой гэрээ байгуулан гүйцэтгүүлж, тайланг хүлээн авсан

- Сүлжмэлийн болон оёдлын нийт 10 жижиг дунд үйлдвэр шинээр байгуулагдан ажиллаж байна.

-Хонины ноосны хялгас ялгах дамжлагын хаягдал хялгас, анхан шатны боловсруулалтын хаягдал шороог боловсруулах үйлдвэрийг Дархан-Уул аймагт Эко ноос ХХК-д байгуулсан.

-Сурагчийн дүрэмт хувцасны зориулалттай монгол хонины ноосон даавуу үйлдвэрлэх, хонины ноосон ээрмэл үйлдвэрлэх, сүлжмэл хувцас үйлдвэрлэх үйлдвэрүүдийг чадавхижуулах ажлыг мэргэжлийн холбоодтой хамтран зохион байгуулж байна. Дүрэмт хувцасны үйлдвэрлэлд оёдлын 7 тэргүүлэх, туслан гүйцэтгэгч 55 үйлдвэр, хонины ноосны хялгас ялгах 3, ээрэх 6, сүлжмэлийн 11 тэргүүлэх туслан гүйцэтгэгч 33 үйлдвэрийг хамруулж, ханган нийлүүлэлт хийж байна. Шинээр 108 үйлдвэр, 2632 ажлын байр шинээр бий боллоо. Сурагчийн дүрэмт хувцасны зориулалттай :

- Ноосон даавуу - 855 мян.т.метр
- Ноосон ээрмэл- 31.5 мян тонн
- Дүрэмт хувцас- 228300 ш
- Сүлжмэл майк, кардиган -144 мян. ш үйлдвэрлэсэн. Бүгд 6.9 тэрбум төгрөгийн борлуулалт хийгдсэн

-2013 оны эхний хагас жилд 13000 хос савхин гутал, 2 мянган хос бүс, тэлээ 3000 цүнх үйлдвэрлэн нийлүүллээ.

-Баянхонгор ХХК хаягдал боловсруулах технологи, техник оруулж ирж ажиллахаар төсөл боловсруулсан нь дэмжигдсэн.

-Арьс шир боловсруулах үйлдвэрийн хатуу хог хаягдлыг боловсруулан бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэрийн ТЭЗҮ боловсруулсан.

- Хан-Уул дүүргийн 14 дүгээр хороо, Сонгинохайрхан дүүргийн 20 дугаар хорооны нутгийн заагт 50 га газарт “Арьс ширний үйлдвэрийн цогцолбор байгуулах дэд бүтцийг барих ТЭЗҮ судалгаа, зураг төсөл, төсвийн материалыг тодотгож, дэд бүтцийг барих нарийвчилсан судалгааны талаар Турк, Испани, Франц, Израйль, Японы мэргэжилтнүүдтэй хамтран ажиллаж, харьцуулсан судалгаа хийж байна.

Ажлын үр дүнд Арьс ширний үйлдвэрийн цогцолбор байгуулах байршлыг судалж, Засгийн газрын 2013 оны 7 дугаар сарын 6-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, 249 дүгээр тогтоолоор шийдвэрлэв.

- Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй малчид, түүхий эд бэлтгэгчид, хоршоодыг түүхий эдээ бэлтгэх, арьс ширэнд анхан шатны тордолт хийх талаар гарын авлагыг боловсруулан хэвлүүлж, орон нутагт 20 аймгийн бүх сумдад 1550 төлөөлөгчийг Засаг даргын тамгын газар, Арьс ширний үйлдвэрийн холбоодтой хамтран томилж ажиллуулж байна.

- Орчин үеийн дэвшилтэт технологи бүхий цэвэрлэх байгууламж Ховд аймагт байгуулах тендерийн баримт бичгийг боловсруулж, Ховд аймагт шилжүүлсэн.

Бусад

- Оёдол, нэхмэл, сүлжмэлийн үйлдвэрүүдэд техник, технологийн шинэчлэл хийхэд зориулж, Чингис хаан бондын санхүүжилтээс Засгийн газрын 2013 оны 126 дугаар тогтоолоор Ноолуур боловсруулах салбарт 68.0 сая ам.доллар, 141 дүгээр тогтоолоор Ноосны салбарт 45.0 сая а.доллар, Оёдлын салбарт 13.5 сая ам.долларийн хөнгөлөлттэй нөхцөлөөр зээл олгохоор тус тус шийдвэрлэв.

Ноолуур боловсруулах үйлдвэрийн 20 төсөлд 24.3 тэрбум, ноос боловсруулах 6 төсөлд 14.6 тэрбум төгрөгийн, Оёмол бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн чиглэлээр “Эксклюзив” ХХК, “Зорбиом” ХХК, “Аминарайсинг” ХХК зэрэг үйлдвэрүүдэд 1227.5 сая төгрөгийн зээл тус тус олгосон.

- УИХ-ын 2012 оны 74 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх хүрээнд арьс ширийг гүн боловсруулах болон бэлэн бүтээгдэхүүний үйлдвэрүүдийг хөгжүүлэх чиглэлээр ирүүлсэн төслүүдийг шалгаруулан арилжааны банкинд уламжилсан.

-Ламинатан шалны үйлдвэр байгуулахаар төлөвлөж байгаа “Эн Эф Ти” ХХК-ийн үйлдвэрлэлийн үйл ажиллагаатай танилцан, ламинатан шал үйлдвэрлэх төслийг хамтран боловсруулж, Японы иений зээлд хамруулахаар төслийг Хөгжлийн банкинд хүргүүлээд байна.

- Дархан-Уул аймагт “Эко ноос” ХХК 6,4 тэрбум төгрөгийн, Баянхонгор аймагт “Хонгор ноос, экспорт” ХХК-д барилгын дулаалгын материал үйлдвэрлэх үйлдвэр байгуулахад 3.8 тэрбум төгрөгийн зээл тус тус олгоод байна.

---oO---